



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар

А/143

Улаанбаатар хот

Тооллого явуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1, 12.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газар, нийслэлийн Аврах анги-105, Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад тусгагдсан эд хөрөнгөд бүртгэлийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн ажлын 4 хоногт багтаан тооллого явуулсугай.

2. Эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Э.Эрдэнэбаатар

Газрын дэд, Гамшгийн Шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа,

Гишүүд:

Б.Сэрдамба

Санхүү, эдийн засгийн хэлтсийн техник тоног төхөөрөмж хариуцсан инженер, ахмад,

З.Мөнх-Од

Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн Холбоо, зарлан мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад,

О.Мөнхбат

Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Хөдөлмөр хамгаалал, хорт хий

Ч.Батболд

утаанаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад, Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ эрсдэлийн удирдлагын тасгийн мэргэжилтэн, ахмад,

Г.Амгалан

Санхүү, эдийн засгийн хэлтсийн нягтлан бодогч, дэслэгч,

С.Алтангэрэл

Нийслэлийн Аврах анги-105-ын Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,

Ш.Айжан

Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургагч багш, ахмад,

Нарийн бичгийн дарга:

Ө.Мөнх-Отгон

Захиргааны удирдлагын хэлтсийн Төлөвлөлт, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, дэслэгч

3. 2019 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг үр дүнтэй явуулж, үүргээр хангаж, тооллогын дүнг үнэн зөв тусгаж, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, танилцуулахыг Ажлын хэсэг (дэд хурандаа Э.Эрдэнэбаатар)-т үүрэг болгосугай.

4. Шаардагдах шатахууны зардлыг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА,  
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН